



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/140

Мандалговь

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлагуудын 2022 оны
үйл ажиллагааны үр дүнгийн тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66.1, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 12.1, 12.3, 12.5, 12.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн нэгдсэн дүнг нэгдүгээр хавсралтаар, хяналт шинжилгээ, үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх нийтлэг зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас тэмдэглэлээр өгсөн нийтлэг зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн ажиллаж, зөвлөмжийн хэрэгжилтийг 6, 11 сарын 25-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнаж ажиллахыг агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр “Санаачилгатай сайн” үнэлэгдэж тэргүүн байр эзэлсэн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг Засаг даргын өргөмжлөл 1,000,000 (Нэг сая) төгрөгөөр, дэд байр эзэлсэн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрыг Засаг даргын өргөмжлөл 800,000 (Найман зуун мянга) төгрөгөөр, гутгаар байр эзэлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг Засаг даргын өргөмжлөл 500,000 (таван зуун мянга) төгрөгөөр тус тус шагнасугай.

4. Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр дутагдалтай үнэлэгдсэн Стандарт хэмжилзүйн хэлтэс, Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Соёл урлагийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба зэрэг агентлагуудад удирдамж гарган байгууллагын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Н.Түвшинжаргал)-т даалгасугай.

483100373

5. Тэргүүн байр эзэлсэн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргыг сарын үндсэн цалин, дэд байр эзэлсэн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргыг сарын үндсэн цалингийн 90 хувь, гутгаар байр эзэлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг сарын үндсэн цалингийн 80 хувь, Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдад үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг байгууллагын төсөвтөө багтаан шийдвэрлэхийг агентлагийн дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

6. Үйл ажиллагааны үр дүнгээр 1,2,3 дугаар байр эзэлсэн агентлагуудын шагналд шаардагдах 2,508,500 (Хоёр сая таван зуун найман мянга таван зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

7. Агентлагуудад өгсөн нийтлэг зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, холбогдох зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, зөвлөн тусалж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ГАЗАР ХЭЛТЭС, АГЕНТЛАГИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛЭЭНИЙ ДҮНГИЙН
НЭЛТГЭЛ

№	Хэлтэс, агентлагийн нэр	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ			Дундаж	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ				Дундаж	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ		дундаж	хүний хөгжлийг дэмжих жил, тусгайлан орчуулсан 9 заалт	Ерөнхий үнэлгээ
		АЗДУАХ-ийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хууль тогтоомж, тогтоол шидвэрийн хэрэгжилт	Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт		Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний	байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	TAX-ийн сургалт нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт		мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ	Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтлөлтийн үнэлгээ			
1	БОАЖГ	98	90	97	95.0	97.3	98.9	98.1	88.8	95.8	65	100	82.5	86.9	90.0
2	ГХБХБГ	100	90	100	96.7	98.1	99.9	98.4	86.5	95.7	80	100	90.0	88.7	92.8
3	УЛУОШГ	100		99.1	99.6	100.0	96.2	96.5	84.1	94.2	80	95.3	87.7	92.1	93.4
4	СХЗХ	100		92	96.0	100.0	86.3	93	61.9	85.3	30	86	58.0	75.5	78.7
5	ХХААГ	79	70	96.2	81.7	90.9	88.9	95.9	72.3	87.0	65	100	82.5	71.5	80.7
6	МЭГ	100	70	69.6	79.9		91.1	88.4	55.0	78.2	30	94.7	62.4	62.0	70.6
7	ОНӨГ	55	70	100	75.0	100.0	91.2	91.6	64.6	86.9	70	98	84.0	82.5	82.1
8	СХ			93.8	93.8		95.2	97.9	73.4	88.8	75	93.3	84.2	80.1	86.7
9	СХДАА	100		96.7	98.4	100.0	96	93.7	59.7	87.4	70	92.7	81.4	71.7	84.7
10	ТХ	100		93	96.5	96.6	95.3	99	84.2	93.8	75	98.7	86.9	76.5	88.4
11	НДХ	100		81.2	90.6	95.3	90.2	93.2	55.5	83.6	30	98	64.0	80.4	79.6
12	ХХҮГ	100	100	86.1	95.4	88.7	91	97.3	88.2	91.3	95	90.7	92.9	77.9	89.4
13	ГБХХГ	100	92.3	98.2	96.8	71.5	88.2	92.8	75.9	82.1	40	98.7	69.4	73.7	80.5
15	ЭМГ	93.7	30	64.2	62.6	88.4	95.2	95.1	78.4	89.3	85	82.7	83.9	87.7	80.9
16	СУГ	96	80	92.8	88.0	90.3	95	95.5	56.8	84.4	30	98	64.0	81.3	79.4
14	БТСГ	100	100	84.8	97.6	100.0	95.8	91.2	71.8	89.7	30	98	64.0	74.5	81.5
17	БШУГ	99	70	84.8	84.6	95.1	92	90.7	84.2	90.5	60	98.7	79.4	85.0	84.9
18	ЭМДХ			100	100.0		86.5	90.5	45.0	59.0			0.0	58.3	72.4
19	УБХ	100	30	100	76.7	100.0	96.1	98	83.7	94.5	70	100	85.0	88.0	86.0
20	ЦГ		92.5	75.6	82.8	90.7	94.7	96.7	71.0	88.3	30	100	65.0	87.8	81.0
21	ШШГТ			100	100.0	100.0	92.5	89.3	57.3	84.8	30	97.3	63.7	86.7	83.8
22	ШША			100	100.0	70.0	96	88.5	44.3	74.7	30	92	61.0	71.6	76.8
23	ОБГ	99.2	100	88.4	95.9	90.4	96.4	96.3	59.4	85.6	70	98	84.0	73.2	84.7
	ДҮН	94.7	77.5	91.3	90.6	93.2	93.4	94.2	89.0	86.5	56.4	95.9	76.2	78.9	83.0

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 сарын ...-ны
өдрийн дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

(Handwritten signatures and stamps)



АГЕНТЛАГУУДАД НИЙТЛЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

1. Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг аймгийн сайтад 5 сарын 1-ний дотор багтаан бүрэн байршуулах.
2. Сар бүрийн эхний 10 хоногийг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг эрчимжүүлэх өдөр болгон үр дүнтэй ажил зохион байгуулж, хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэх
3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг шинэчлэн батлуулж, үзүүлэлтийн үр дүнг сум бүрээр гарган эмхэтгэл хийж иргэдэд мэдээлэх
4. Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хавсралтаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 10а хавсралтын дагуу төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолон батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх
5. Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалт, цахим албан хэрэг хөтлөлтийн тайланд улирал бүр дүгнэлт хийж, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст цахимаар ирүүлэх.
6. Цахим хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, аймаг орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх талаар тогтмол анхаарч үр дүнг сар бүр тооцон ажиллах
7. Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэл, үүрэг даалгаврын цахим системд шилжиж, нийт албан хаагчдын цахим ур чадвар, тоон боловсролыг дээшлүүлэх
8. Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдалд улирал бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангах
9. Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, явцын тайланг Нийгмийн бодлогын хэлтэст 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах.
10. Төрийн албаны тухай хуулийн 55.3-ын дагуу байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар батлан хэрэгжилтийн тайланг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй хамт нотлох баримттайгаар тайлагнаж байх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС